



## СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 01 сарын 20 өдөр

Дугаар 9/06

Улаанбаатар хот

### Үндэсний стандарт шинэчлэн батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.3, 11 дүгээр зүйлийн 11.3.1, 11.3.3, 11.3.4, 25 дугаар зүйлийн 25.3.2, Үл эвдэх сорилын стандартчиллын техникийн хороо (ХХ 45)-ны 2020 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Гагнуур. Ган, диц, жуугаан ба тэдгээрийн хайлшийг хайлуулж гагнасан холболт (цацрагийн гагнуур хамаarahгүй). Согогийн чанарын түвшин, MNS ISO 5817:2021” стандартыг улсын хэмжээнд хэрэглэхээр хүлээн зөвшөөрч үндэсний стандартаар шинэчлэн баталсугай.

2. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төвийн зөвлөлийн 2002 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 08 дугаар тогтоолоор баталсан “MNS ISO 5817:2002, Гангийн цахилгаан нуман гагнууран холболт. Согогоор чанарын түвшинг үнэлэх арга зүйн заавар” стандартыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Шинэчлэн баталсан стандартыг улсын мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн өдрөөс эхлэн мөрдсүгэй.

4. Шинэчлэн баталсан стандартыг сурталчилах ажлыг зохион байгуулахыг Үл эвдэх сорилын Монголын нийгэмлэгт зөвлөмжилсүгэй.

